



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.5, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын уран зургийн галерейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нийт 41,794,724.93 (дөчин нэгэн сая долоон зуун ерэн дөрвөн мянга долоон зуун хорин дөрвөн төгрөг ерэн гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Монголын уран зургийн галерейн захирлын үүрэг гүйцэтгэгч А.Янжинжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ



0001700

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 1-ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

Монголын уран зургийн галерейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
акталж, данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Балансын			Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
					нэг бүрийн	нийт үнэ			
1	Гал унтраах автомат систем (2011)	ш	1	4/27/2011	4,501,770.00	4,501,770.00	4,501,770.00	-	
2	Галын болон хамгаалалтын дохиоллын систем (2011)	ш	1	4/27/2011	8,308,050.00	8,308,050.00	8,308,050.00	-	
3	Камерийн хяналтын систем (2011)	ш	1	4/27/2011	20,672,179.93	20,672,179.93	20,672,179.93	-	
4	Харьцангуй чийгшил хэмжигч	ш	1	2/20/2013	382,647.00	382,647.00	382,647.00	-	
5	Гэрэлтүүлэгч (Вспышка)	ш	1	1/1/2007	832,885.00	832,885.00	832,885.00	-	
6	Гүйдэг хана хаалт	ш	6	1/1/1999	20,000.00	120,000.00	120,000.00	-	
7	Гэрэл зургийн мини студи (зөөлөн гэрэл 2	ш	1	1/1/2007	439,990.00	439,990.00	439,990.00	-	
8	Цаг бүртгэлийн төхөөрөмж	ш	1	6/30/2010	250,000.00	250,000.00	250,000.00	-	
9	Босоо хана	ш	5	12/26/2012	30,000.00	150,000.00	150,000.00	-	
10	Бүтээл зөөх тэргэнцэр	ш	1	12/27/2011	6,137,203.00	6,137,203.00	6,137,203.00	-	
Нийт дүн					41,794,724.93			41,794,724.93	0
					(дөчин нэгэн сая долоон зуун ерэн дөрвөн мянга долоон зуун хорин дөрвөн төгрөг ерэн гурван мөнгө)				